



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/660

Булган сум

Г Ажлын хэсэг томилох тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66.1.13, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.7, 32.1.8, 32.1.10, 32.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Шадар сайд, аймгийн Засаг даргатай 2023 онд байгуулсан гэрээний дагуу 2023 оны 10 дугаар сард “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг”-ийг зохион байгуулах, бэлтгэлийг хангах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг”-ийн бэлтгэл ажлын нэгдсэн төлөвлөгөө, “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах, үнэлэх журам”-ын дагуу аймгийн Онцгой комисс удирдлага штабыг идэвхжүүлэн, гамшгаас хамгаалах алба, ерөнхий болон тусгай зориулалтын мэргэжлийн ангийн хүн хүч, техник, хэрэгслийг татан оролцуулсугай.

3. Бэлтгэл хангахтай холбоотой зардлыг гамшгаас хамгаалах тухай хуулийн 32, 33, 34, 51 дүгээр зүйлийг үндэслэн шийдвэрлэхийг төсөв захирагч сумын (Булган, Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн, Сайхан, Сэлэнгэ, Хангал, Хутаг-Өндөр, Тэшиг) Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсэг, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн дарга нарт даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулахыг ажлын хэсэг (Д.Жаргалсайхан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр  
сарын 15-ны өдрийн А/660 дугаар  
захирамжийн хавсралт

**“ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГ” ЗОХИОН БАЙГУУЛАХ  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Ажлын хэсгийн дарга:** - Аймгийн Засаг даргын орлогч Д.Жаргалсайхан
- Орлогч дарга:** - Онцгой байдлын газрын дарга, хурандаа Ш.Баасандорж
- Гишүүд:**
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга  
Д.Алтаншагай
  - АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга  
Д.Эрдэнэбилэг
  - АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга  
Д.Батцогт
  - АЗДТГ-ын Цэргийн штабын дарга, дэд хурандаа  
Ч.Энхбаяр
  - Хөгжимт жүжгийн театрын дарга О.Ууганчимэг
  - Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн дарга
  - Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгт хамрагдах  
сумдын Засаг дарга
- Нарийн бичгийн дарга:**
- Онцгой байдлын газрын орлогч,  
дэд хурандаа Д.Ууганбаяр
  - Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах төлөвлөлт,  
бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн,  
дэд хурандаа Н.Хишигдорж
  - Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгт хамрагдах  
сумдын Засаг даргын Тамгын газрын дарга